

"Монголын нууц товчоон"-ы уг эхийн талаар эргэцүүлэх нь*

Шагдарсүрэн Ц.
/МУИС/

-
1. Товч удиртхал
 2. Эрдэмтдийн гол санал
 3. Нэмэрлэх баримт
 4. Нэмэрлэсэн санал
- ABSTRACT
Хавсралт 1-8.
-

1. "Монголын нууц товчоон" (цаашид *МНТ* гэж товчилоно) хэмээх гайхамшигт бүтээлийн анхны буюу уг эхийн талаар судлагчид өдгөө болтол санал нэгдээгүй бөлгөө. Үүнд: Э. Хэниш (E. Haenisch), С.А. Козин, Поль Пеллио (Paul Pelliot), К. Ширатори (K. Shiratori), Л. Лигети (L. Ligeti), Ф.В. Кливез (F. W. Cleaves), Ц. Дамдинсүрэн, Баяр, И. Ринчен, Ш. Гаадамба, Д. Цэрэнсодном, Ш. Чоймаа зэрэг зонхи хэсэг нь *МНТ*-ы анхны эхийг худма монгол бичгээр байсан гэж үздэг. Харин О.Франке (O. Franke) зэрэг зарим судлагч *МНТ*-ыг анх монгол хэлээр, хятад үсгээр байсан гэдэг саналтай бөлгөө. Үүнээс гадна *МНТ*-ыг монгол дөрвөлжин бичгээр байсан гэж үздэг гуравдагч санал ч буй ч XVII зууны үеийн монгол түүхийн сурвалжуудад хийсэн сүүлийн үеийн үсэгзүйн судлагаанаас үзэхэд улс төрийн бодолгын үүднээс *МНТ*-ны нэг эх монгол дөрвөлжин бичигээр байсан байх боломжтой ч түүнээс өмнө монгол бичигээр байсан гэдэгийг нутлах батлагаа улам бүр итгэлтэй болсоор байгаа бөгөөд энэ талаар хойно арай дэлгэрүүлэн өгүүлэх болно.

Энэхүү илтгэлд *МНТ*-ы уг эх монгол бичгээр байсан гэж үздэг үзэлд холбогдуулан нэгэн баримтыг нэмэн танилцуулах зорилго тавилаа.

* Энэхүү өгүүлэл нь *МНТ*-ы 750 жилийн ойд зориулж 1990 оны наймдугаар сарын 14-19-нд Улаанбаатар хотноо болсон Олон улсын Бага хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэлийн нэмж зассан хоёдугаар хувилбар болой. Уг илтгэл үүнээс өмнө монгол эхээрээ нийтлэгдээгүй, харин англи товчлол нь 1994 онд Соул хотноо (*Mongolian Studies, The Korean Association for Mongol Studies*, n. 2. Seoul. pp. 120-123) хэвлэгдсэн билээ. Эл хувилбарт харьцангуй сүүл үед олдсон холбогдох баримт хэрэглэгдэхүүнийг аль болохуйц хамрахыг оролдсоны дээр бас бус таамаглал дүгнэлтийн зүйлийг нэмэн оруулсан бөлгөө.

2. Уг баримтыг өгүүлэхийн өмнө *МНТ* анх монгол бичгээр байсан хэмээн үзэж буй эрдэмтдийн гол үндэслэлийг авч үзсүгэй. Үүнд: 1960 хэдэн оноос академич Л. Лигети *МНТ*-ы анхны эхийн талаар хэдэн гол санааг дэвшүүлэхдээ О. Франкегийн таамаглал үндэслэл муутай хэмээн баримтаар тайлбарлаад уйгур (? Ц.Ш) монгол бичгээр байсан гэдгээ хэд хэдэн зүйлээр батлаж, бидний үетэй золгон ирсэн *МНТ*-ы эх бол монгол хэл сурч судлах хэлмэрч, орчуулагч хятад түшмэлд зориулсан хувилбар эх гэж үзсэн байдаг бөлгөө (1-р хавсралтаас үзмүү)¹.

Америкийн нэрт монголч, нангиадач эрдэмтэн Ф. В. Кливез "*Монголын нууц товчоон*"-ы англи орчуулгаа 1956 онд дуусгаж 1957 онд хэвлэлд шилжүүлсэнээ дахин нягтлахаар буцаан авч засан зассаар 1982 онд хэвлүүлсэн бөгөөд үүндээ *МНТ*-ы анхны эх (N.1) нь уйгур (энд "*монгол бичиг*" гэсэн утгаар буй. Ц.Ш.) бичгээр "*Чингис хааны язгуур*" гэдэг нэртэй байсан, дараа нь уул эхийн мөр хоорондуур нь хэрхэн дуудах байдлыг хятад үсгээр авиачлан буулгаж үг бүрийн орчуулга болон хүний хийгээд газар усны нэр гэх зэргээр тайлбар нэмсэн (N.2) эх буй болсон хэмээжээ. Үүний дараа мөр хооронд авиачилан нэмсэн хятад галиг болон орчуулга тайлбар сэлтэд дулдуйдсан "*Юан чао би ши*" ("*Юан гүрэний нууц судар*") нэртэй хятад хураангуй орчуулга бүхий (N.3) эх гарсан гэж үзжээ. Дараагийн шатанд, уугуул монгол эхийг орхиж, (N.2) эхийн мөр хоорондын авиачилсан хятад галиг сэлт нь бие даан голлож (N.3) эхийн хураангуй орчуулгын хамт (N.4) эх болсон... гэж тал талын олон баримт сэлтийг бодолцсон, учир шалтгааны хувьд нарийн холбоо бүхий дүгнэлт дэвшүүлсэн байдаг².

3. Академич Л. Лигети, Ф.В. Кливез авгай нарын санал, таамаглал нь *МНТ*-ы анхны эх монгол бичгээр байсан гэдгийн хувьд бие биеэ нөхсөн нэгдмэл зүйл болж байгаа билээ. Харьцангуй хожуу үед хамаарч буй боловч дээрхи саналын тухайд шууд холбогдохын сац улам ч нуттай болгох нэгэн баримтыг авч үзэцгээе.

Төв Ази дахины олон улс үндэстний дунд, ялангуяа нангиад бичигт суурилсан соёл боловсролын хүрээнд *Lao Kida* (老乞大) буюу *Лао цидэ* (солонгос нэр нь: *Mong-ō nogōl-tae*; цаашид бид *ЛЦД* гэж товчлоно) гэдэг бие даасан сурах бичгийн нэгэн зүйл уламжлал байсан ажээ. *ЛЦД*-гийн талаар товч тайлбарлахад, энэ нь албаны орчуулагч, хэлмэрч нарт зориулж, судлагдахуун болж буй хэлний хэрэглэгдэхүүнийг хэрхэн дуудах байдалыг мөр мөрөөр нь галиглан хадаж, дүйх орчуулгы нь нэмэн хавсаргасан тусхай ном бөлгөө. *ЛЦД*-г түүхчилэн үзвэл дотроо хятад, монгол, манж зэрэг хэлний *ЛЦД* гэж байсан ажээ³.

Энэ хир бидний үед хүрэлцэж ирсэн монгол хэлний *ЛЦД* маягийн ном гэвэл солонгос хүнд зориулан харьцангуй ойролцоо барлагдсан гурван ном буй. Тухайлбал: нэгд, 1741 онд анх модон бард гарч дараа нь 1776, 1790 онд зохих завсар оруулсан, солонгосоор *Mong-ō nogōl-tae* (蒙語老乞大) хэмээх монгол хэлний сурах бичиг нь

¹ Lajos Ligeti, *A Mongolok titkos története*, Budapest, 1962, 191-214; Louis Ligeti, *Histoire secrète des Mongols*, Budapest, 1971, p. 7.

² F.W. Cleaves, *The Secret History of the Mongols*, Volume 1, Translation, London, 1982, pp. ix-ixiii.

³ *Men gu Lao kida*, - Source Materials for Korean Studies N. 3. Research Institute for Humanities Sogang University, Seoul, 1983, p. 410.

дотроо найман бөлөг (2-р хавсралтыг үзмүү); хоёрт, 1737 онд анх барлагдаж улмаар 1790 онд засвар оруулсан гэдэг, солонгосоор *Ch'ôphae Mong-ô* (捷解蒙語) хэмээдэг монгол хэлний сурах бичиг, дотроо дөрвөн бөлөг (3-р хавсралтаас үзнэ үү); гуравт, мөн 1790 онд засаж гаргасан, солонгосоор *Mong-ô yuhai* (蒙語類解) гэдэг монгол хэлний зүйл хуваасан сургалтын толь эдгээр болой. Үүнээс эхний хоёр нь бүтэц, загварын хувьд адил, солонгосын *Hunmin chông 'üm* (訓民正音) бичгээр дуудалгы нь хадсан монгол бичвэртэй, өгүүлбэр тус бүрийн дараа солонгос орчуулга хадаастай Харин гуравдугаарт дурдсан монгол хэлний зүйл хуваасан сургалтын толь *Mong-ô yuhai*-д нь монгол бичиг байхгүй, харин монгол хэлний хэрэглэгдэхүүний дуудалгыг хятадаар галиглаж солонгосоор дуудалга болон орчуулгыг хаджээ (7-р хавсралтаас үзнэ-үү).

Одоогийн байдлаар *Mong-ô nogôl-tae* нь Сөүлийн Их сургуулийн Номын сангийн Куујанггак хөмрөг, Японы Тоуо Bunko Номын сан, Парист l'Ecole des Langues Orientales Vivantes сургуулийн номын санд нэжгээд хувь хадгалагдаж байна. *Ch'ôphae Mong-ô* нь Солонгосоос гадна Парис хотноо, дээр дурдсан сургуулийн номын санд⁴ нэгэн хувь буй ажээ.

Mongo nogol-tae-гийн төгсгөлийн үгнээ "...манай сургууль (энэ нь Монгол бичгийн сургууль гэдгийг хэлж байна Ц. Ш.)-ийн түшмэдийн унших боловсруулах монгол бичиг хэд буй боловч үсэгийн аялгуу, үзэгийн дүрэм, бэлгэ арга үсэг нийлүүлж хэрэглэх хууль бүдгэрэв. Иймийн тул зовсон нь их..." хэмээн уг номыг зохион гаргасан учирьг тайлбарлажээ⁵.

Энэ бүхнээс эргэцүүлвэл, солонгос үсгээр монгол бичвэрийн дуудалгыг хадаж, солонгос орчуулга хавсаргасан *Mong-ô nogôl-tae*, *Ch'ôphae Mong-ô* хэмээх хоёр сурах бичиг нь профессор Ф. В. Кливез авгайн дурдсан МНТ-ы (N.3) хувилбартай; монгол бичвэргүй бөгөөд зөвхөн хятад үсгээр дуудалгыг галиглан тэмдэглэж орчуулга хавсаргасан *Mong-ô yuhai* хэмээх сургалтын толь нь МНТ-ы (N.4) хувилбартай зарчмын хувьд буюу зохиомж, бүтэцийн хувьд бүрэн тохирч байна гэж үзэх үндэстэй ажээ.

Үүнээс гадна бас нэмж тэмдэглэх нэгэн зүйл буй. Бидний дээр өгүүлсэн зүйлийг дундад зуунаа Төв Азийн олон орноо нийтлэг хэрэглэгдэж бараг уламжлал болчихсон гадаад хэлний сурах бичгийн тогтсон зарчим гэж үзэх боломжтой ажээ. Үүнд: монгол хэлнийхээс гадна хятад, манж хэлний ЛЦД гэж байсан тухай бид дээр өгүүлсэн билээ⁶. Манж хэлний ЛЦД буюу *Chong-ô nogôl-tae* (清語老乞大) нь бүтэц агуулгаараа *Mong-ô*

⁴ Louis Ligeti. *Rapport preliminaire d'un voyage d'Exploration fait en Mongolie Chinoise*. Budapest. 1977. pp.35-36. Энэ мэдээнээс уламжлаж монгол хэлний дээр дурдсан гурван сурах бичгийн хэлзүйн судлагаа хийсэн. Солонгосын Dankook Их сургуулийн Монголын судлалын салбарын эрхлэгч профессор И Сон-гю (Lee Seong-Gyu) болон энэхүү өгүүллийг бичигчийн хүсэлтээр Францын монголч эрдэмтэн Мари-Доминик Эвэн Парис хотноо хадгалагдан буй хоёр дурсгалын бичил хуулбарыг илгээсэн бөгөөд тэдгээр нь Солонгост хадгалагдан буй зохих зохих эхтэй яг тохирч байгааг дурдахын сац бидний хүсэлтийг ёсоор болгосон номын нөхөр Мари-Доминик Эвэнд гүнээ талархаж буйгаа илэрхийлсү.

⁵ *Men gu Lao kida*. - Source Materials for Korean Studies N. 3. Research Institute for Humanities Sogan University. Seoul. 1983. p. 409.

⁶ *Men gu Lao kida*. - Source Materials for Korean Studies N. 3. Research Institute for Humanities Sogan University. Seoul. 1983. p. 410.

nogöl-tae–тай бараг адилхан, аль аль нь найман дэвтэр, хавсралттай ажээ (4-р хавсралтыг үзнэ үү). Нэгэнт гадаад хэлний ийм нэгэдмэл сурах бичиг байсаны хажуугаар мөн зарчим нэгтэй сургалтын толь бичиг байсан байх бүрэн магадлалтай бөлгөө.

Тэгвэл тийм Толь бичгийн зүйл байна уу? гэдэг асуулт аяндаа гарах нь мэдээж юм. Үүний хариу болгож бид *И-юй*⁷ (譯語 I-iu ~ I-yu) маягийн толь бичиг ийм зарчимтай байсан гэж хэлмээр байна. *И-юй* маягийн толийг ерөнхийд нь авч үзвэл зөрчид, сиам, төвөд, уйгур, самгард, перс хэлнийх⁸ гэж байдаг бөгөөд цаг хугацааны хувьд голдуу Мин улсын үед холбогддог боловч дээр дурдсанчлан олон хэлний *И-юй* толь байгаа нь түүнээс өмнө тухалбал Юан гүрний үед нэгэнт уламжлал болчихсон байжээ гэж үзэх бүрэн үндэстэй бөлгөө. Үүнээс гадна тухайн нэгэн хэлний *И-юй* маягийн толь нь дотроо ч хэд хэдэн зүйл байсан ажээ. Тухайлбал: монгол хэлний *И-юй* маягийн толь гэхэд *Хуа-и и-юй* (華夷譯語, 5, 5.а-р хавсралтыг үзнэ-үү), *Монгол и-юй* (蒙古譯語, 6-р хавсралтыг үзнэ-үү), *Жи-юан и-юй* (至元譯語) гэх буюу бас зохиосон газрын нэрээр өвөр зуураа ялгаатай байсан бөлгөө⁹. Эдгээр толь нь зохиомж байдалын хувьд өвөр зуураа ялгаатай. Үүнд: *И-юй* маягийн толийн зарим хувилбарт толгой үг нь монгол бичвэртэй¹⁰, түүндээ хятад үсгээр дуудалга болон орчуулгыг нь хадсан байдаг нь мөн л ЛЦД-гийн зарчимтай нэгэн адил¹¹ гэж үзэх бүрэн үндэстэй. Нөгөө зарим нь монгол бичвэргүй, монгол толгой үгийн дуудалга орчуулгыг ханзаар шууд тэмдэглэсэн байдал¹² нь “*Монголын нууц товчоон*”-той зарчим адил бөлгөө.

Хуа-и и-юй толь бичгийн тухайд бас нэмж хэлэх нэгэн онцлог буй. Үүнд: бид уг номыг *Хуа-и и-юй толь* гэж нэрлэдэг болохоор олонхи хүн зөвхөн толь бичиг гэж боддог. Гэтэл *Монгол хуа-и и-юй* (蒙古華夷譯語) болон *Зөрчид* [女真/女眞: Nü-chen; 女直: Nü-chih] *Куан и-юй толь* (女眞館譯語 / 女直館譯語)¹³ бичгийн бүтэцийг үзэхэд уг тольд багтсан толгой үгийг *Тэнгэрийн зүйл*, *Газарын зүйл*, *Хүний зүйл* гэх мэтээр 20-иод зүйл болгон хуваасан толь бичгийн хажуугаар янз бүрийн утга агуулга бүхий 10 гаруй

⁷ Ц. Шагдарсүрэн, *Толь бичгийн судлал*, - Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс, Улаанбаатар, 1985, (169-240) 203-206-р талд үзмүү.

⁸ Gisaburo N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Reconstruction and Decipherment, Kyoto, 1977, pp. 28-29.

⁹ Ц. Шагдарсүрэн, *Толь бичгийн судлал*, - Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс, Улаанбаатар, 1985, (169-240) 203-206-р тал; L. Ligeti, *Un Vocabulaire sino-mongol des Yuan, Le Tche-Yuan Yi-yu*, - Acta Orientalia Hung., Tom. XLII (3), Budapest, 1990, pp. 259-277; G. Kara, *Zhiyuan Yiyu, Index alphabetique des mots mongols*, - Acta Orientalia Hung., Tom. XLII (3), Budapest, 1990, pp. 279-344; Ö. Mandaqu, *Mongyol i iiii toli bičig*, Begejing, 1995; Ö. Mandaqu, *Quva i i iiii toli bičig*, Begejing, 1998.

¹⁰ Ц. Шагдарсүрэн, *Толь бичгийн судлал*, - Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс, Улаанбаатар, 1985, (169-240) 203-206-р тал.

¹¹ Х. Лувсанбалдан, Боошиан, *Хуа-и-и-юй толь бичгийн зарим хэсэг*, - “Хэл зохиол түүх” сэтгүүл, 1959, VII, VIII, 1960, (Хөх хот); Ö. Mandaqu, *Mongyol i iiii toli bičig*, Begejing, 1995;

¹² L. Ligeti, *Un Vocabulaire sino-mongol des Yuan, Le Tche-Yuan Yi-yu*, - Acta Orientalia Hung., Tom. XLII (3), Budapest, 1990, pp. 259-277;

¹³ Gisaburo N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Reconstruction and Decipherment, Kyoto, 1977, pp. 28.

бичвэрийг тусхайлан хавсаргасан байдаг¹⁴ нь найруулан бичих дадал суулгах загварын үүрэгээр хэрэглэгдэж байсан ажээ.

4. Дээр өгүүлсэн хэрэглэгдэхүүнд үндэслэж ямар дүгнэлт гарч болох вэ? гэвэл академич Л. Лигети, Ф.В. Кливез нарын саналыг тэтгэн лавшируулж, дараахи нутлагааг нэмэрлэж болно гэж бодож байна.

4. 1. *МНТ*-ны анхны эх монгол бичгээр байсан гэдэг саналыг солонгос хүнд зориулан зохиосон монгол хэлний *ЛЦД* маягийн сурах бичгүүд давхар батлаж байна. XI зуунаас Монголчууд түүхийн тавцанаа товойн гарч ирэхэд Ази дахины олон орон, ялангуяа хил нийлж нутаг савлан оршоор ирсэн Хятадын хувьд монгол хэл сурах, судлах явдал улам бүр шаардагдаж, орчуулагч, хэлмэрчийн албаны олон түшмэдэд монгол хэл сургангаа монголчуудын үүх түүхийг давхар судлуулах зорилгоор *МНТ*-ы анхны эхийг үндэс болгон тухайн цагийнхаа гадаад хэлний сурах бичигийн загвараар бэлдэхэн хэрэглэж байсан нь Хаан ордны номын санд хадгалагдан үлдсэн буй заа. *МНТ*-д буй мэдээ сэлтийг товч болон дэлгэрэнгүйгээр агуулсан "*Алтан товч*", *Хураангуй Алтан товч*", "*Эрдэнийн товч*", "*Асарагч нэрт(ийн) түүх*" зэрэг сурвалж бичигүүдийг эх бичигийн алдаа судлалын үүднээс ажиглахад *МНТ*-ы анхдагч эх нь монгол бичигээр, тэр тусмаа согджин (үүнийг уйгуржин гэж нэрлэж хэвшсэн) хэлбэрээр байсан гэж үзэх бүрэн үндэслэл хэдийнээ буй болжээ (8-р хавсралтыг үзмүү). Үүнд: *МНТ* болон дээр дурдсан түүхэн сурвалжуудад $q \sim s$, $g \sim s$ үсгийг сольж хольсон "тогтолцоотой" гэж хэлж болохуйц алдаа мадагийн учир холбогдолыг үзэхэд XVII зууны манай түүхчид монгол (согджин) бичгээр асан *МНТ* болон *МНТ*-ыг бичихэд ашигласан хэрэглэгдэхүүнийг уг эхээр нь үзжээ гэх баттай баримт бэлхэнээ харагдах¹⁵ бөгөөд энэ талаар профессор Ш. Чоймаа нарын тусхайлан бичсэн зүйл ч буй.

4. 2. Дундад зуунаа, Хятадаас гадна хятад хэл бичигийн хүрээнд гүнээ хамрагдсан Ази дахины олон оронд гадаад хэлний сурах бичиг нь *ЛЦД* маягийн, сургалтын толь бичиг нь *И-юй* маягийн байсан гэж үзэх үндэслэл гарч байна.

Эцэст тэмдэглэх нэгэн зүйл: "*Монголын нууц товчоон*" хэмээн бидний нэрлэсээр ирсэн энэ гайхамшигт туурвилын уг монгол нэр нь өдгөөгийн дуудалгаар "*Чингис хааны язгуур*" гэж байсан бөгөөд одоо бидний "*Монголын нууц товчоон*" гээд байгаа маань чухамдаа Минг улсын үед нэг сумаар хоёр туулай унагана гэгчээр монгол хэлийг сурангаа монголын түүхийг давхар мэдэх зорилгоор уг монгол эхийн дуудалгыг ханзаар тэмдэглэсэн хувилбар эхэд нэмж бичсэн "*Юан чао би ши*" (元朝秘史) хэмээх хятад

¹⁴ A. Mostaert, *Le Matériel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*, I, par Igor de Rachewiltz. Bruxelles, 1977; A. Mostaert, *Le Matériel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*. II (Commentaires), par A. Mostaert et Igor de Rachewiltz. Bruxelles, 1995. Gisaburo N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Reconstruction and Decipherment. Kyoto, 1977; Jin Qicong, *Nuzhenwen zidian* (Jurchen Dictionary), Peking, 1984, p. 300+67;

Dorj, *The First Research on the Pronunciation of Jurchen* (in Chinese), Өвөр Монголын Их сургууль, "Эрдэм шинжилгээний сэтгүүл", Хөххот, 1983, pp. 1- 240. Daniel A. Kane, *The Sino-Jurchen Vocabulary of the Bureau of Interpreters*, Indiana, Bloomington, 1989, pp. 11-22.

¹⁵ Ш. Чоймаа, *Лу "Алтан товч"-ийг "Монголын нууц товчоон"-той харьцуулсан судалгааны нэг тал*, - *Acta Mongolica*, Vol. 1(182), Ulaanbaatar, 2002, 83-94; Ц. Шагдарсүрэн, Lee Seong-Gyu, *Byamba-yin Asarayci neretü(-yin) teüke*, Эхбичигийн судлагаа, - [Monumenta Mongolica (CMS, NUM) - Tomus I], Улаанбаатар, 2002; Ш. Чоймаа, "*Монголын нууц товчоон*", *Лувсанданзаны "Алтан товч"* Эхийг харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2002.

нэрийн утгачилсан орчуулга, энд Монгол гэсэн үг ч байхгүй гэдэгийг хэлэх нь зүйтэй буй заа гэж санана. Агуулгын хувьд ч гэсэн хожим нэмсэн гэж үздэг Хубилайтай холбоотой багахан хэсэгийг эс тооцох бөгөөс Юантай холбоотой зүйл энэ бүтээлд байхгүй. Хэрэвзээ эхбичиг, сурвалж судлалын үүднээс ч, уламжлалаа баримтлан дээдлэхийн үүднээс ч "Монголын нууц товчоон"-ы "Чингис хааны узуур (язгуур)" хэмээх уугуул монгол нэрий эргэн тэнхрүүлэх бөгөөс уг туурвилынхаа мөн чанарт үлэмжхэн тохирох болно гэж эрхгүй санагддаг. Харин энэ талаар анхаарч уг бүтээлийн монгол хэлээрхи бичвэрийн "Чингис хааны узуур" хэмээн гарчиг байдлаар бие даалган бичсэн хамагийн эхний мөрийг Бөххэшиг авгай Энх Эрдэмтийн наймдугаар он буюу 1941 онд гар бичмэл хэлбэрээр чулуун бараар хэвлүүлсэн "Монголын нууц тууж" номынхоо монгол бичвэрийн эхинд мөн л "Činggis qayan-u ijaγur" хэмээн гарчиг байдлаар байрлуулсан гэдэгийг дурдалгүй өнгөрөх аргагүй¹⁶.

Ханз галигаар бидний үед уламжилан ирсэн "Чингис хааны узуур (язгуур)" болон бусад сурвалжуудад нэр тэмдэглэгдсэн боловч уг эхээрээ хүрэлцэн ирээгүй түүхэн бүтээл туурвилууд нь Их Монгол улс болон түүнээс өмнөхи үед зохиогдохдоо яг монголын түүх зохиоё гэсэн эрмэлзэл гэхээсээ илүү хан цагаан ястан - ихэс дээдэсийнхээ удам угсааг тодруулан гаргах зорилготой байжээ гэж үзэх үндэс тодорхой харагддаг¹⁷. Харин XVI-XVII зууны үед тухайн цаг үеийн учир шалтгаанаар үндэсний ухамсар үлэмжхэн сэргэж үүх түүхээ тодруулан бичих зорилгоор түүхэн зохиол далайн давалгаа мэт хойно хойноосоо шил даран гарсан байдал харагдах бөгөөд чухам тэр үед тэдгээр түүхэч нарын гарын дор одоо бидний мэдэхгүй өдий төдий сурвалж, ордоны тэмдэглэл болон ихэс дээдэсийн язгуур гаралын хэлхээс, "Чингис хааны узуур (язгуур)" (буюу "Монголын нууц товчоон")-ыг зохиоход ашигласан бараг бүх эх сурвалж (согджин) монгол бичигээр цөм байсан гэдэг нь улам тодорхой болсоор байна. Наад зах нь Инжаннашийн "Хөх судар" гэхэд уранзохиолын үүднээс хэдийгээр түүхэн роман гэж үздэг ч, нарийвчилан сайтар тунгаах бөгөөс хаан ордоны тэмдэглэлээс наад зах нь зарлиг, албан бичигийн зүйлийг бүхэл бүхэлээр нь шигтгэж ашигласан тухай Монгол Гуулин хоёр улсын харилцааны түүхийн баримт түшиж доктор Б. Сумъяабаатарын тэмдэглэсэн зүйлийг анхаарахгүй байхын аргагүй.

¹⁶ *Mongyol-un niγuša turyūji* (Nigen debter). Mongyolγilaysan kümün Bökekesig, Engke erdemtü-yin naimaduγar on (1941), γurban sar-a-yin qorin-a, 298 tal-a.

¹⁷ Ц. Шагдарсүрэн. *Монголчуудын утга соёлын товчоон*, Улаанбаатар, 2003, 161-170-р тал.

ABSTRACT

ON THE QUESTION OF THE FIRST ORIGINAL TEXT OF "THE SECRET HISTORY OF THE MONGOLS"*

1. Scholars do not agree about the first original text of "*The Secret History of the Mongols*" (which I shall refer to as SHM). In general, many scholars (E. Haenisch, S.A. Kozin, P. Pelliot, K. Shiratory, L. Ligeti, F. W. Cleaves and Sh. Gaadamba...) consider that SHM was originally written in Mongolian script. However, others say it was written in Chinese script; and others - it was in hPags-pa script.

In this paper, I would like to outline a number of points referring to proofs and conclusions that the first original was written in Mongolian script.

2. Since the 1960's academicien L. Ligeti has put forward a number of proposals on the first original text of SHM proving the incredibility of the hypothesis of O. Franke. According to his opinion, the SHM was written in Mongolian script and the one which came to us was devoted to Chinese officials and translators¹.

Professor F.W. Cleaves, a mongolist and sinologist, translated the SHM in 1956 and published it in 1982 after studying it thoroughly. He mentioned:

"... A tentative textual lineage of the *Yüan-ch'ao pi-shih* may, therefore, be represented in its main lines schematically as follows:

1. *Mongolian original (in the Uighur script) entitled * *Činggis qayan-u ujayur* [*The Origin of Činggis qayan*].

2. *Mongolian original (in the Uighur script) entitled * *Činggis qayan-u ujayur* [*The Origin of Činggis qayan*] with the Chinese interlinear transcription and glosses.

3. *Abridged Chinese translation entitled *Yüan-ch'ao pi-shih* [*The Secret History of the Yüan Dynasty*].

4. * Chinese interlinear transcription- somewhat modified from that in no.2 - and glosses, both derived from no. 2, with the Mongolian original (in the Uighur script) deleted, but with the abridged Chinese translation derived from no. 3 added, the whole - including the colophon - arbitrary divided into 282 sections and entitled *Yüan-ch'ao pi-shih*...."²

3. The opinions and verifications of L. Ligeti and F.W. Cleaves mutually complement each other. To prove it, I quote a fact.

Among Asian nations, in particular, in the framework of the a culture based on Chinese hieroglyphs, there are an independent tradition of Manual called *Lao Kida* (LK) and dictionary called (*Hua-i*) *i- yü*. In brief, this both are a special type of school appliances for interpreters and translators to use for pronunciation and sources and to target language word equivalents. If we examine historically, the tradition of the LK there was LK of Chinese,

* This abstract is enlarged version of the Paper of the International Conference dedicated to the 750th Anniversary of "*The Secret History of the Mongols*", 14-19 August, 1990, Ulaanbaatar.

¹ Lajos Ligeti. *A Mongolok titkos története*, Budapest, 1962. 191-214; Louis Ligeti. *Histoire secrète des Mongols*, Budapest, 1971. p. 7.

² Francis Woodman Cleaves. *The Secret History of the Mongols*, Vol. I (Translation). London, 1982. p. ix-ixi

Mongolian and Manchu languages³. For the special type of (*Hua-i*) *i-yü* dictionaries, there are Mongolian, Jurchen, Siamese, Shan, Tibetan, Uighur, Sanskrit, Persian...languages⁴.

A monument of the *LK* that came to us was printed in 1741, with xylography. It was reprinted in 1776 and 1790. Mongolian text were explained in Korean phonetic transcription and translated into Korean. Copies of it are kept in Seoul University Library, Tokyo Toyo Bunko Library and Paris l'Ecole des Langues Orientales Vivantes' Library⁵. In 1983 it was published in photo copy form for public by Research Institute for Humanities, Sogan University, S-Korea in No. 3 of "*Source Materials for Korean Studies*"⁶.

The principle of the Mongolian *LK* is similiar to the *SHM* composition. Therefore, there are grounds for saying that there was the principle of a special type of foreign language manual, as Mongolian *LK*, in 13th Century designed for Chinese interpreters and translators. In accordance with F.W. Cleaves' opinion, by its principle the Mongolian *LK* corresponds to copy no. 2 of the *SHM*.

4. What conclusion can be made? The following, I think, can be added to the opinion and conclusion of prof. L. Ligeti and F. W. Cleaves.

The Mongolian *LK* testified that the first original text of the *SHM* was written in Mongolian script. In the 12-13th centuries, when the Mongols became strong in the field of history, Asian countries, in particular, China, the southern neighbour of Mongolia needed to learn and study the Mongolian language and historical past. So, in the China, no. 4 of the *SHM* was composed in the composition of the special type of foreign language manual of that time, as Mongolian *LK*. This copy of the *SHM*, as Chinese interlinear transcription, with the abridged Chinese translation might have been kept in the King's Palace Library, in Pekin.

Concerning "*I-yü*" type dictionaries, it may served as a training dictionary for foreigners in the Central Asian peoples under the influence of the Chinese hieroglyph.

³ *Men gu Lao kida*. - Source Materials for Korean Studies N. 3. Research Institute for Humanities Sogan University, Seoul. 1983. p. 410.

⁴ Ц. Шагдарсүрэн. *Толь бичгийн судлал*. - Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс. Улаанбаатар. 1985. (169-240) 203-206-р тал.

L. Ligeti. *Un Vocabulaire sino-mongol des Yuan, Le Tche-Yuan Yi-yu*. - Acta Orientalia Hung., Tom. XLIV (3). Budapest. 1990. pp. 259-277.

G. Kara. *Zhiyuan Yiyu, Index alphabetique des mots mongols*. - Acta Orientalia Hung., Tom. XLIV (3). Budapest. 1990. pp. 279-344.

Ö. Mandaqu. *Mongyol i üüi toli bičig*. Begejing. 1995.

Ö. Mandaqu. *Quva i i üüi toli bičig*. Begejing. 1998.

A. Mostaert. *Le Materiel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*. I. par Igor de Rachewiltz. Bruxelles. 1977.

A. Mostaert. *Le Materiel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*. II (Commentaires). par A. Mostaert et Igor de Rachewiltz. Bruxelles. 1995.

Gisaburo N. Kiyose. *A Study of the Jurchen Language and Script*. Reconstruction and Deciphrement, Kyoto. 1977. pp. 28-29.

Dorj. *The First Research on the Pronunciation of Jurchen* (in Chinese). Өвөр Монголын Их сургууль. Эрдэм шинжилгээний сэтгүүл. Хөхот. 1983. 1- 240.

Daniel A. Kane. *The Sino-Jurchen Vocabulary of the Bureau of Interpreters*. Indiana, Bloomington. 1989. pp. 11-22.

⁵ Louis Ligeti. *Rapport preliminaire d'un voyage d'Exploration fait en Mongolie Chinoise*. Budapest. 1977. pp.35-36.

⁶ *Mongolian Lao Kida*. Source Materials for Korean Studies No.3. by Research Institute for Humanities. Sogan University, Seoul. 1983.

"Юан гүрэний нууц түүх" гэдэг нэрээр хүрэлцэн ирж
(түүнээс үүдэн бидний "Монголын нууц товчоон" гэх болсон) "Чингис хааны узуур"

ХЭМЭЭХ


их туурвилын уг эхийн эхний хуудасны байдал

[1]

元朝秘史	
名 皇帝的 根源	
成吉思汗忽儿	
上 天 命 有的	生 了 的 苍 色 狼 有
洪 額 騰 格 理 額 扯 札 牙 阿 禿	脫 列 先 字 兒 帖 赤 阿 禿
妻 他 的 慘 白 色 虎 有 來	水 名 渡 着 來 了
格 兒 赤 納 喀 埃 馬 蘭 阿 只 埃	騰 汲 思 客 禿 周 亦 罷
河 名 河 的 源 行 山 名 行 營 盤 做 着	
幹 難 木 連 帖 里 元 捏 不 耶 牙 哈 敦 納 嫩 禿 刺 周	
元 秘 史 一	一
生 子 的 人 名 有 來	
脫 列 先 巴 塔 赤 罕 阿 主 元	
當初元朝的人祖。是天生一箇蒼色的狼。與一箇慘白 色的虎相配了。同渡過騰吉思名字的水。來到於幹難	
名字的河源頭。不見罕名字的山前住。 着。產了一箇人名字喚作巴塔赤罕。	
的 子 名 的 子 名	
巴 塔 赤 罕 納 可 溫 塔 馬 察 塔 馬 察 因 可 溫 豁 里 察 兒 篋 兒 干	
的 子 名 的 子	
豁 里 察 兒 篋 兒 干 納 可 溫 阿 兀 站 字 羅 溫 阿 兀 站 字 羅 兀 倫 可 溫	

[2]

"Юан гүрэний нууц түүх" гэдэг нэрээр хүрэлцэн ирж
(түүнээс үүдэн бидний "Монголын нууц товчоон" гэх болсон) "Чингис хааны узуур"
хэмээх
их туурвилын уг эхийн нэгэн хэсэгийн байдал




Монгол "Lao kida" буюу "Mong- ö nogöl-tae" гийн нэгэн хуудасны байдал

蒙語老乞大卷之一	이거 아바개 치 하나사 이러비 디셔온다 곤兄아테어	비 초그한 왕 기ंग 어취 이러비 셔왔노라 내 朝鮮王京	오도 하나 어치 더가느다 비 버거징 연 即수어지	죽 어치워 하야가노라 치 거져 왕 내北京으로向	기ंग 어취 몰다바 셔혀난다 비 어터사라 내인저王京	연 시너 연 니건 두 왕 기ंग 어취
-----------------	--	---	---------------------------------------	--------------------------------------	---	-----------------------------

Солонгос хэлээрхи *Ch'ôphae Mong-ô* хэмээх
монгол хэлний сурах бичигийн эхний хуудас

쓰고 하여 비치취 들 타마 가 서쿨	새한 외란 비치취 고림을잘기독 비침과덤과동	려어노여외오고 처음으로反切을 아 쿠슬 빈두 기	웅신 볼바수라줄 고 쳐거지러워	투타 알반 호알 토론개 기	捷解蒙語第一
--	--	--	-------------------------------------	---------------------------------------	---------------

Солонгос хэлээрхи Манж ЛЦД буюу Chong-ō nogōl-tae-гийн
нэгэн хуудасны байдал



"Хуа и и юй толь" толь бичигийн нэг хуудасны байдал

華夷譯語	
天文門	
天 騰吉里	日 納蘭
月 撒刺	星 火敦
風 克	雲 額兀連
烟 忽紉	霜 乞刺兀
冰 莫勒孫	雪 察孫
雷 騰吉里董幣敦	霖 主薛
一	
雨 怵刺	露 石兀迭鄰
虹 莎部哈	霧 抹你牙兒
電 急里別里干	雹 門都兒
天河 騰吉里因幹牙刺兒	
地理門	
地 冷札兒	土 石刺兀
山 阿兀刺	林 槐
河 木鏈	湖 納兀兒

Монгол толгой үг бүхий
"Хуа и и юй толь" толь бичигийн эхний хуудас

華夷譯語

天文門

多

天

騰吉里

多

日

納蘭

"Монгол и юй толь" бичигийн нэг хуудасны байдал

[illegible]

"Mong-ö yuhai"-гийн нэг хуудасны байдал

蒙語類解上卷

天文

天道

하늘

○ 텡거리

天文

하늘

○ 텡거리 연운하

天河

하늘

○ 텡거리 연운하

日頭

하늘

○ 나란

日出

하늘

○ 나란 갈바

日落

하늘

○ 나란 우나바

日珥

하늘

○ 나란 호시라바

月兒

하늘

○ 사란

蒼天

하늘

○ 쿠거 텡거리

天變

하늘

○ 텡거리 연후빛할

天涯

하늘

○ 텡거리 연홀외

日光

하늘

○ 나란 丁거럴

日矚

하늘

○ 나란 타시바

日暈

하늘

○ 나란 쿠러러바

日蝕

하늘

○ 나란 바리워

月亮

하늘

○ 사란 사라쿨

蒙語類解上

一

蒙語類解上

“Чингис хааны узуур” (буюу “Монголын нууц товчоон”) -ын
уугуул монгол эхийг сэргээвэл ийм буюу...
(Ш. Чоймаа нарын сэргээсэн эхээс)

[illegible]